



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/09

Мөрөн сум

Арга хэмжээний жагсаалт, төсөвт
өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.2, 39 дүгээр зүйлийн 39.4, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6 аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2021 оны ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Ойжуулалт нөхөн сэргээлт хийх арга хэмжээ, ойн санг гэрээгээр эзэмшин хамгаалж буй нөхөрлөл, аж ахуй нэгж байгууллагыг урамшуулах ажлын жагсаалт, төсөвт өртгийг задаргааг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт даалгасугай.

3. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулагдах 62,000,000 (Жаран хоёр сая) төгрөгийг аймгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, арга хэмжээний зардлын батлагдсан төсвөөс холбогдох хууль, журамд нийцүүлэн гүйцэтгэлээр нь санхүүжүүлэх, төлөвлөгдсөн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тухай бүр тооцож, тайлагнаж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны дүгээр
сарын-ний өдрийн дугаар
захирамжийн хавсралт

ОЙЖУУЛАЛТ НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХ АРГА ХЭМЖЭЭ, ОЙН САНГ ГЭРЭЭГЭЭР
ЭЗЭМШИН ХАМГААЛЖ БУЙ НӨХӨРЛӨЛ, ААНБ-ЫГ УРАМШУУЛАХ АЖЛЫН
ТӨСӨВТ ӨРТӨГ

ЗДҮАХ-ын дугаар	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Хугацаа
Ойн хомсдол доройтлыг бууруулах замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлж, Зүй зохистой хамгаалахад чиглэсэн тогтвортой менежментийг бий болгоно.				
Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлж, нөхөн сэргээх, ойн санг гэрээгээр эзэмшин хамгаалж буй нөхөрлөл, ААНБ-ыг урамшуулал олгоно.	Ойжуулалтын ажлыг зохион байгуулж, ойн санг гэрээгээр эзэмшин талбайн хэмжээг нэмэгдүүлж идэвхи санаачилгатай ажилласан нөхөрлөл, ААНБ-ыг урамшуулна.	Ойжуулалт нөхөн сэргээлт хийх арга хэмжээ	57,6	2022
		Ойн санг гэрээгээр эзэмшин хамгаалж буй нөхөрлөл, ААНБ-ыг урамшуулах	4,4	2022
Нийт дүн			62,0	-